



БОДЬ ДААТГАЛ
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 25/01

Улаанбаатар хот


Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг удирдлага болгон Бодь даатгал ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

А.ЭНХЖАРГАЛ



2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

2024 онд Монгол улсын эдийн засгийн бодит өсөлт 5,7 хувь, инфляцын түвшин 8,5 хувь гарсан бол даатгалын салбарын цэвэр хураамж 15,3 (3-р улирлын байдлаар) хувиар өссөн байна. Цэвэр хураамжийн өсөлтөд тээврийн хэрэгслийн даатгалын хураамж болон гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, хөрөнгө болон хариуцлагын даатгалын цэвэр хураамж өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

“Бодь Даатгал” ХК-ийн хувьд 2024 онд санхүүгийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай гарсан байна. Үүнд:

Хураамжийн орлого

Нийт хураамжийн орлого 11,07 хувиар өсөж 32,1 тэрбум, цэвэр хураамжийн орлого 0,2 хувиар өсч 22.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Цэвэр хураамжийн орлогын 86 хувийг гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, тээврийн хэрэгсэл, хөрөнгө хариуцлагын даатгал бүрдүүлж байна.

Компани 2024 оны жилийн эцсээр даатгалын цэвэр хураамжийн төлөвлөгөө 91.5%-ийн гүйцэтгэлтэй гарсан ба орон нутгийн төлөвлөгөөний гүйцэтгэл 75%-тай гарсан нь нийт гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Төлбөрийн чадварын үзүүлэлт

Даатгалын төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтийн зохистой түвшин 130 % байхаас гүйцэтгэл 233 %-тай гарсан нь 2-р түвшин буюу хангалттай үзүүлэлттэй гарчээ.

Нөөцийн сан

2024 оны байдлаар нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ 9,19 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 32.6 хувиар буюу 2.7 тэрбум төгрөгөөр өсгөж зохистой түвшинд байгуулж ажилласан байна.


Компанийн цэвэр хосолсон харьцаа 110.5% гарсан ба зардлын харьцаа, хохирлын харьцаа зохистой түвшинд байх ба хосолсон харьцаа зохист түвшнээс 5,5 хувиар давсан нь орлого тооцсон хураамж 2 тэрбумаар буурсан нь нөлөөлсөн байна.

Ашигт ажиллагаа

Тайлант үеийн цэвэр ашиг 2.5 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 92.3%-иар өсөж хуримтлагдсан ашиг 44,1 % буюу 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь компани 2024 онд хангалттай сайн ажилласан гэж үзэж байна.

Цаашид даатгалын хосолсон харьцааг зохистой түвшинд барьж, андррейтингийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж даатгалын борлуулалтыг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг илүү өсгөж ажиллахад анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БИЛЭГТ

